



**Дорнод аймаг дахь
Төрийн аудитын газар**
Үндэсний Аудитын газрын нэгдсэн
төлөвлөгөө, удирдамжийн дагуу
хийсэн нийцлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮАГ-НАГ/2017/01-НА



**Аймгийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгасан хөрөнгө
оруулалтын ажлуудыг хийсэн боловч дотоод хяналт хангалтгүй,
урсгал зардалд зарцуулсан байна.**

Чойбалсан хот

2017 он

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын Нийцлийн
аудитын алба

Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Болортуул
Утас: 70584203

Аудитын менежерийн
үүргийг түр орлон
гүйцэтгэгч Д.Нармандах
Утас: 70584207

Ахлах шинжээч
Ж.Баяртуул
Утас: 70584207

Шинжээч
С.Энхбаатар
Утас: 70584207

2017 оны 04 дүгээр
сарын 26

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын
утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлсэн боловч сумдад хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн дагуу хуваарилаагүй байна.

1.1. ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг журмын дагуу тооцож төлөвлөсөн байна.

1.2. Аймаг ОНХС-гийн эх үүсвэрийг журмын дагуу тооцож төлөвлөсөн байна

1.3. Аймаг, сумд ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу бүрдүүлсэн байна.

1.4. Аймгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу хуваарилж, олгоогүй байна.

II Бүлэг: ОНХС-гийн хөрөнгийг хууль, журамд нийцэхгүй урсгал зардалд зарцуулсан байна.

2.1. Аймгийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгасан хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

2.2. Сумдууд нь 33,5 сая төгрөгийн хууль, журамд нийцэхгүй хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөн, баталж, санхүүжүүлсэн байна.

2.3. Аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 300,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээг ТЭЗҮ-гүйгээр баталсан байна.

2.4. Сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 144,0 сая төгрөгийн 2 худалдан авалтыг хийхдээ тендер шалгаруулалтын аргыг буруу сонгосон байна.

2.5. Сумдууд ОНХС-гийн хөрөнгөөр 38,6 сая төгрөгийн урсгал зардалд зарцуулсан байна.

2.6. Төсөл хөтөлбөрт ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагууд захиалагчийн хяналтыг хийж, санхүүжилтийг олгосон байна.

2.7. ОНХС-гаас санхүүжүүлсэн 365,3 сая төгрөгийн хөрөнгийг орлогоор аваагүй, эзэмшигч тодорхойгүй байна.

III Бүлэг: ОНХС-гийн зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтын хууль, журам хэрэгжихгүй байна.

3.1. Аймаг, сумын ИТХ нь ОНХС-гийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

3.2. ОНХС-гийн хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.

3.3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний мэдээллийг зааврын дагуу мэдээлсэн байна.

3.4. ОНХС-гийн заавар нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.

3.5. ОНХС-гийн зарцуулалтад хийсэн 2015 оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ

ЗӨВЛӨМЖ

АЛБАН ШААРДЛАГА

ТӨЛБӨРИЙН АКТ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СОНХС	Сумын орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ОНОХАА	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс
ТЭЗҮ	Техник, Эдийн засгийн үндэслэл
ШХА	Шууд худалдан авалт
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХТШ	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ХА	Харьцуулалтын арга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудитор ТҮАГ болон Дорнод аймаг дахь Төрийн Аудитын газрын 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

ОНХС-гийн 2016 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан дүнг аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчийн хурал, Засаг дарга нар болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад ОНХНС, аймаг, сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, СТСХ, ХОХБТХ, Багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулж, ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилт, тайлагнал, хяналт зэргийг авч үзнэ.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Монгол Улсын “2016 оны төсвийн тухай” хуульд ОНХНС-гаас Дорнод аймагт олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 5,0 тэрбум төгрөгөөр баталсныг “Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-аар 4,1 тэрбум төгрөг болгон өөрчилсөн байна.

Аймгийн ОНХС-гаас сумдад олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, АДБОУС, Нийцлийн аудитын 4000-4200 дугаар стандарт, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дэд хөтөлбөр боловсруулан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авах, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын нөхцөл байдал, үр дүнд шинжилгээ хийх, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, анхан шатны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, бодит байдал дээр оршин байгааг үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай хууль
- 2016 оны төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-гаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ батлах тухай”
- Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Заавар батлах тухай”
- Сангийн Сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан “Тендерийн жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай”
- Сангийн Сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар баталсан “Тендерийн жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай”
- Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, нийцлийн аудитын албаны ахлах шинжээч Ж.Баяртуул, шинжээч С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхэлж, 04 дүгээр сарын 25-ны өдөр дуусган дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, албан шаардлага, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажууллаа.

I Бүлэг. ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлсэн боловч сумдад хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн дагуу хуваарилаагүй байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг журмын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг анх 5,0 тэрбум төгрөгөөр баталжээ.

Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2012 оны “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан аргачлалд үндэслэн 60 хувь буюу 3,0 тэрбум төгрөгийг сумын ОНХС-нд, 40 хувь буюу 2,0 тэрбум төгрөгийг аймгийн ОНХС-нд олгохоор төлөвлөсөн байна.

Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан УИХ-аас Монгол Улсын 2016 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 4,1 тэрбум төгрөг буюу 894,7 сая төгрөгөөр бууруулан баталсан бөгөөд уг орлогын шилжүүлгийг аймаг, сумдад олгохоор төлөвлөхдөө сумдад 54,7 хувь буюу 2,2 тэрбум төгрөгийг, аймагт 45,3 хувь буюу 1,9 тэрбум төгрөгийг тооцож төлөвлөсөн байна.

Энэ нь Засгийн газрын 2012 оны “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх “Энэ аргачлалын 2.2.1¹-д заасан эх үүсвэрийг сум, дүүргийн хөгжлийн санд хуваарилахад Төсвийн тухай хуулийн 59.2-т заасныг мөрдлөг болгоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Аймаг ОНХС-гийн эх үүсвэрийг журмын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Аймаг, сумд ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д заасан дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

1. ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг 4,1 тэрбум төгрөг.
2. Аймаг сумын үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг 219,3 сая төгрөг.
3. Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламж 300,0 сая төгрөг.
4. Бусад орлого 82,5 сая төгрөг.

1.3. Аймаг, сумд ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу бүрдүүлсэн байна.

Аймаг, сумд ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасан нэр, төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна. Үүнд:

¹ 2.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг

ОНХС-д төвлөрүүлсэн эх үүсвэрийн судалгаа

/сая төгрөг/

№	Нэрс	Эх үүсвэрийн гүйцэтгэл					
		ОНХНС-аас олгох шилжүүлэг	Орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр	Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж	Бусад орлого	Нийт эх үүсвэр
1	Аймаг	1'873,8	88,4	-	246,6	20,2	2'229,0
2	Сумд	2'266,8	130,9	-	-	62,3	2'460,0
	Нийт дүн	4'140,6	219,3	-	246,6	82,5	4'689,0

Дээрх хүснэгтээс үзэхэд аймаг, сумд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэрээс бусад төрлийн эх үүсвэрээс төвлөрүүлсэн байна.

1.4. Аймгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу хуваарилж, олгоогүй байна.

Аймгийн ОНХС-гаас сумдад олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-д заасны дагуу баталсан байна.

ОНХНС-гаас олгох аймаг болон сумдын ОНХС-гийн шилжүүлгийн төлөвлөгөө болон гүйцэтгэл

/сая. төгрөг/

№	Нэрс	Олгох санхүүжилт	Олгосон санхүүжилт	Санхүүжилтийн зөрүү
1	Аймаг	1'656.2	1'873.8	-217.6
2	Сумд	2'484.4	2'266.8	217.6
	Нийт дүн	4'140.6	4'140.6	-

Хүснэгтээс үзэхэд ОНХНС-гаас олгосон шилжүүлгийг 5,3 хувь буюу 217,6 сая төгрөгөөр сумдад дутуу, аймагт илүү хуваарилж олгосон нь Төсвийн тухай хуулийн 59.2² дахь “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3³-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ОНХС-гаас олгох санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу тооцож үзэхэд 1, 2, 3, 4, 6, 8 дугаар саруудад нийт 673,2 сая төгрөгийг дутуу, 5, 7, 9, 10, 11, 12 саруудад нийт 1'095,2 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна. Эдгээр нь сумдын ОНХС-гийн хөрөнгийн санхүүжилт сүүлийн саруудад төсвийн хүндэрлийн улмаас Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 291 дүгээр тогтоолын дагуу эхлээгүй болон хэрэгжих боломжгүй гэж үзсэн ажлуудын санхүүжилтийг олгохгүй байх зарчмыг баримтлан, ОНХНС-гаас аймагт олгох санхүүжилтийг хугацаанд нь олгоогүйтэй холбоотой байна.

² 59.2 Аймаг, нийслэл нь ОНХНС-гаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна.

³ 59.3 ОНХС-гаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно.

59.3.1 Орон нутгийн хөгжлийн индекс

59.3.2 Хүн амын тоо

59.3.3 Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ

59.3.4 Орон нутгийн татварын идэвх санаачлага.

II Бүлэг. ОНХС-гийн хөрөнгийг хууль, журамд нийцэхгүй урсгал зардалд зарцуулсан байна.

2.1. Аймаг хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгасан хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд 225 төрлийн 5,1 тэрбум төгрөгийн өртөгтэй төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр тодотгож төлөвлөсөн нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

ОНХС-гийн төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” баталсан журмын дагуу 05 дугаар сард багтаан багийн Засаг дарга нар БИНХ-аар урьдчилсан жагсаалтыг танилцуулж, иргэдийн саналыг авч баталгаажуулсан байна.

2.2. Зарим сумд 33,9 сая төгрөгийн хууль, журамд нийцэхгүй хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөн, батлаж, санхүүжүүлсэн байна.

Аймгийн Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг олон нийтэд нээлттэй, ил тод хэлэлцүүлж байгаа боловч, төсөл арга хэмжээний жагсаалтыг хууль, журамд заасны дагуу эрэмбэлж, үнэлэлт дүгнэлт өгөхгүйгээр аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө батлагдсан маягтын дагуу иргэдээс санал авсан, саналгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлаагүй байна.

Харин Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн заавар батлах тухай” журмын 4.4⁴, 4.5⁵, дахь заалтуудыг

- Түймэр унтраах шатахуун болон хоол хүнсний зардалд Баян-Уул сумын ЗДТГ 12,5 сая төгрөг, Цагаан-Овоо сумын ЗДТГ 3,2 сая төгрөг,
- Байгаль орчны сургалт, нийтийн биеийн тамир, боловсрол дэмжих, хүүхэд харах төв, ахмад залуучуудын ТББ-д гэсэн 5 хөтөлбөрийн зардалд Матад сумын ЗДТГ нийт 18,2 сая төгрөгийг хууль журамд нийцэхгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

2.3. Аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 300,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 хөрөнгө оруулалтыг ТЭЗҮ-гүйгээр баталсан байна.

Тайлант онд шинээр төлөвлөгдсөн 4.0 тэрбум төгрөгийн өртөгтэй 185 төсөл арга хэмжээнээс зураг төсөв, ТЭЗҮ, техникийн тодорхойлолт шаардлагатай 1.8 тэрбум төгрөгийн 14 төсөл арга хэмжээ байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн ИТХ-д зураг төсөв, ТЭЗҮ, техникийн тодорхойлолтгүй 300.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг өргөн барьж батлуулсан байна. Үүнд:

- Өрхийн тариалан эрхлэлтийг дэмжих, дэд бүтэц татах -50.0 сая төгрөг
- “Сургуулийн бүс”, “Цэцэрлэгийн бүс” төсөл хэрэгжүүлэх- 150.0 сая төгрөг
- “Илч” хорооллын гудамжны тохижилт-100.0 сая төгрөг гэсэн зардлууд байна.

⁴ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх”

⁵ “Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-гаас хөрөнгө зарцуулахгүй байх”

2.4. Сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 144,0 сая төгрөгийн 2 худалдан авалтыг хийхдээ тендер шалгаруулалтын аргыг буруу сонгосон байна.

ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлсэн 4,0 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зарласан байна.

ОНХС-гийн тендер худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт

№	ОНХС	НТШ		ХТШ		ХА		ШГБ		ХАА зохон байгуулсан	
		тоо	өртөг	тоо	өртөг	тоо	өртөг	тоо	өртөг	тоо	өртөг
1	Аймгийн ОНХС	7	1'301,2	0	0	7	277,0	0	0	2	24,4
2	Сумдын ОНХС	7	485,2	1	48,0	26	553,8	89	671,6	46	600,6
	Дүн	14	1'786,4	1	48,0	33	830,8	89	671,6	48	625,0

/сая төгрөг/

Төсөвт өртөг нь 50,0 сая төгрөгөөс дээш 2 тоног төхөөрөмжийг худалдан авахдаа шууд худалдан авалтын аргаар гэрээ байгуулан санхүүжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго тогтоох тухай” журманд заасан “Төсөвт өртөг нь 50,0 саяас дээш бараа худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын арга хэрэглэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Хөлөнбуйр сум 65,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дунд оврын униварсаль трактор”,
- Цагаан-Овоо сум 79,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Униварсаль трактор”

Аймаг, сумдын үнэлгээний хорооны гишүүд гүйцэтгэгчийг сонгохдоо Сангийн Сайдын баталсан тендерийн жишиг баримтын дагуу боловсруулан хөтөлж, ажлын хэсэг болон үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжийг үндэслэн ажил болон бараа үйлчилгээ нийлүүлэгчтэй гэрээ байгуулан ажилласан байна.


2.5. Сумдууд нь ОНХС-гийн хөрөнгийн 38,6 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд 2,0 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг хийхээр төлөвлөн баталсан байна. Эдгээр хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хууль болон Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.2 дахь заалтад нийцсэн байдлыг графикаар үзүүлбэл:

График 1⁶

⁶ 7.2.2. “Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх”-д 94,6 сая төгрөг буюу 4,5%,

7.2.6. “Усан хангамж бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах”-д 808,9 сая төгрөг буюу 38,6%,



Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 2016 онд 2.3 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг төлөвлөн баталсан байна. Төсвийн тухай хууль болон Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4 дэхь заалтаар сумдын 2016 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гэрээ байгуулсан төсөл арга хэмжээг багцалж үзүүлбэл:

- 7.4.1. “Сумдын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх” чиглэлд 524,4 сая төгрөг буюу 23,2%,
- 7.4.2. “Малжуулах” чиглэлд 17,4 сая төгрөг буюу 0,8%,
- 7.4.3. “Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх” чиглэлд 548,4 сая төгрөг буюу 24,2%,
- 7.4.4. “Сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах” чиглэлд 20,6 сая төгрөг буюу 0,9%,
- 7.4.5. “Сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах” чиглэлд 253,6 сая төгрөг буюу 11,2%,
- 7.4.6. “Сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах” чиглэлд 360,2 сая төгрөг буюу 15,9%,
- 7.4.7. “Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” чиглэлд 415,7 сая төгрөг буюу 18,3%,
- Үндэсний их баяр наадамд 85,8 сая төгрөг буюу 3,8%,

Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т нийцэхгүй хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- 4.3-д “Төсвийн тухай хуулийн 60.3-д заасан ОНХС-гаас зарцуулахыг

- 7.2.7. “Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх”-д 24,0 сая төгрөг буюу 1,2%,
- 7.2.9. “Аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох”-д 804,5 сая төгрөг буюу 38,3%,
- 7.2.10. “Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах”-д 118,6 сая төгрөг буюу 5,7%,
- 7.2.11. “Аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх”-д 51,5 сая төгрөг буюу 2,4%,
- 7.2.12. “Аймгийн төвд нийгэм-соёлын зориулалттай тохижилт”-д 147,1 сая төгрөг буюу 7%
Улсын их баяр наадамд 50,0 сая төгрөг буюу 2,3%,

хориглосон зүйлд зарцуулахгүй байх”, 4.4-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэсэн заалтуудыг зөрчин “Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах үйл ажиллагааны зардал” буюу түймэр унтраах үеийн шатахуун болон хоол хүнсний зардалд Баян-Уул сум нь 12,5 сая төгрөг, Цагаан-Овоо сум 3,2 сая төгрөг, Матад сум нь “Хогны машины засвар”-т 4,7 сая төгрөг, “мал эмнэлэгийн машин засвар”-2,0 сая төгрөг, “Байгаль орчны сургалт”-д 1,8 сая төгрөг, “Ахмад, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд ТББ”-д дэмжлэг 7,9 сая төгрөг, “Нийтийн биеийн тамир хөгжүүлэх”-д 4,3 сая төгрөг, “Боловсролыг дэмжих”-д 2,2 сая төгрөг нийт 38,6 сая төгрөг,

- 4.5-д “Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-гаас хөрөнгө зарцуулахгүй байх” гэснийг зөрчин Матад сум “Ахмад, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд ТББ” дэмжлэг 7,9 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.6. Төсөл, хөтөлбөрт ГХБХБГ болон мэргэжлийн байгууллагууд захиалагчийн хяналтыг хийж, санхүүжилтийг олгосон байна.

Монгол Улсын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” гэсэн заалтын дагуу аймгийн ГХБХБГ, МХГ-аас аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 1,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээнд захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.

2.7. ОНХС-гаас санхүүжүүлсэн 365,3 сая төгрөгийн хөрөнгийг орлогоор аваагүй, эзэмшигч тодорхойгүй байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн Хэрлэн сумын 2, 5, 17, 25, 49, Дорнод Их сургуулийн багш нарын байрны дээврийн засвар, 50 дугаар байрны дээвэр, цэвэр, бохир усны шугамын засварын 355,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтыг хүлээн авах эзэн тодорхойгүйгээс орлогоор хүлээн зөвшөөрч, капиталжуулаагүй байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 89,3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл, тайланд орлогоор тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг заавал бүртгэнэ, Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6-д “ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд:

- Баяндун сум нь сумын ерөнхий төлөвлөгөөнд 48,0 сая төгрөг, хогийн цэгийн хашаажуулалтад 20,6 сая төгрөг, худаг засварт /3 ш/ 9,0 сая төгрөг.
- Хөлөнбуйр сум нь сумын хөгжил илэрхийлсэн ном бүтээлгэхэд 1,7 сая төгрөг.
- Чулуунхороот сум нь Эрээнцав дахь гаалийн салбарын барилгын гадна талбайн засварт 10,0 сая төгрөг.

III Бүлэг. ОНХС-гийн зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтын хууль, журам хэрэгжихгүй байна.

3.1. Аймаг сумын ИТХ нь ОНХС-гийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 9.1⁷, 9.2⁸ дахь заалтуудыг аймаг, сумдын ИТХ, санхүүгийн хяналт, аудитын алба нь хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Баяндун, Халх гол, Хэрлэн сумаас бусад сумдын ИТХ дэргэдээ Хяналтын хороо байгуулаагүй, 2016 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймаг, сумын ИТХ хяналт тавьж ажиллаагүй зэрэг нь Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалттай нийцэхгүй байна.

3.2. ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Аймаг болон 14 сумаас 13 сум нь 2016 оны ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлсэн, Гурванзагал сум огт ирүүлээгүй нь Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1⁹ дэх заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөөгүй, цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг сум бүрээр гаргаагүй, үр дүнгийн тайланг Сангийн Яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст хүргүүлээгүй нь Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.2¹⁰, 10.3¹¹-дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний мэдээллийг зааврын дагуу мэдээлсэн байна.

Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11.2.3¹²-д заасны дагуу аймаг, сумын ИТХ-аар ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт, төсөвт өртгийг батлан гаргаж, байгууллагын ил тод мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулж иргэдэд танилцуулсан байна.

⁷ 9.1 “ОНХС”-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

⁸ 9.2 ОНХС-гаас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ.

⁹ 10.1 “Сум, дүүргийн ОНХС-гийн хэрэгжилтийн явцад хагас жилийн тайланг жил бүрийн 07 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна”

¹⁰ 10.2 “Ажлын хэсэг ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 02 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ”

¹¹ 10.3 “Аймаг, нийслэл ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор Сангийн Яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст ирүүлнэ”

¹² 11.2.3 “Аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж байна”

Мөн аймгийн хэмжээнд бүх сумын ЗДТГ ил тод байдлын самбар ажиллуулж, самбарт орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөгөө, 2016 онд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг байршуулсан байна.

3.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.

ОНХС-гийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “ОНХС-гаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” зэрэг хууль тогтоомж, заавар журмууд мөрдөгдөж байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”, 60 дугаар зүйлд “Орон нутгийн хөгжлийн сан” гэж заасныг үндэслэж улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдах хөрөнгийг орон нутгийн түвшинд төлөвлөх, батлах, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавихаар Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” ашиглагдаж байна. Тус заавар нь Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “ОНХС-гаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-тай нийцэж байна.

3.5. 2015 оны ОНХС-гийн зарцуулалтад хийгдсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Өмнөх онд хийсэн аудитаар нийт 10,5 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 39,4 сая төгрөгийн 8 албан шаардлага, 736,4 сая төгрөгийн 10 зөвлөмжийг өгсөн. Үүнээс төлбөрийн актыг 100 хувь, албан шаардлагыг 100 хувь, зөвлөмжийн 80 хувийг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх онд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг дараах хүснэгтэд үзүүлбэл:

№	Он	Акт /сая төгрөг/			Албан шаардлага			Зөвлөмж /тоогоор/			Хэрэгжилт-ийн дундаж хувь
		Тавигд-сан	Биелэл-т	хувь	Тавигд-сан	Биелэл-т	хувь	Тавигд-сан	Биелэл-т	хувь	
1	2015	10,5	10,5	100	39,4	39,4	100	10	8	80	93,3

Дээрхээс үзэхэд 2015 оны ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитаар нийт 963,8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 38,6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 365,3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 559,9 сая төгрөгийн 8 зөвлөмж өгч ажиллалаа.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг хуульд заасны дагуу хуваарилаагүй байна.
2. ОНХС-гийн хөрөнгө оруулалтыг аймгийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөтэй уялдуулсан байна.
3. Баян-Уул, Матад, Цагаан-Овоо сумын ЗДТГ нь хуульд нийцэхгүй хөтөлбөр, урсгал зардалд 33,9 сая төгрөгийг зарцуулахаар сумын ИТХ-д өргөн барьж, ИТХ нь баталж, сумын ЗДТГ нь санхүүжүүлсэн байна.
4. ТЭЗҮ-гүй 300,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 хөрөнгө оруулалтыг аймгийн ОНХС-гаар хийхээр баталсан.
5. Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумд нь 144,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтын аргыг буруу сонгосон.
6. Баян-Уул сум 12,5 сая төгрөг, Цагаан-Овоо сум 3,2 сая төгрөг, Матад сум 22,9 сая төгрөг нийт 8 хөтөлбөрт 38,6 сая төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн.
7. ГХБХБГ болон МХГ-ууд нь захиалагчийн хяналтыг тавьж ажилласан байна.
8. Чулуунхороот суманд 10,0 сая төгрөг, Баяндун суманд 77,0 сая төгрөг, аймгийн ОНХС-гаар хийгдсэн 355,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг эзэмшигч тодорхойгүйгээс бүртгэлд тусгаагүй байна.
9. Аймаг сумын ИТХ-аас ОНХС-гийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.
10. ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд эрх бүхий байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй, дүн шинжилгээ хийгээгүй байна.
11. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг зааврын дагуу мэдээлсэн байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох-д:

1. ТЭЗҮ-гүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг батлахгүй байх.
2. Аймгийн ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавих Хяналтын хороог байгуулж, хяналт тавин ажиллах.

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. Аймгийн ОНХС-гаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуульд заасны дагуу хуваарилах, батлагдсан хуваарийн дагуу олгох.
2. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн дээвэр, цэвэр, бохир усны шугамын засварын ажлуудыг бүртгэл, тайланд тусгах, эзэмшигчийг тодорхойлох.
3. Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т заасны дагуу сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж ажиллах.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. СОНХС-гийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа хууль, журамд нийцээгүй төсөл арга хэмжээг батлахгүй байх.
2. ИТХ-аас ОНХС-гийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллах.

Сумдын Засаг дарга нарт:

1. СОНХС-гийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө хууль, журамд нийцэхгүй төсөл, арга хэмжээг ИТХ-д өргөн барихгүй байх.

2. Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу худалдан авалтын аргыг сонгож байх.
3. СОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 87,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд тусгах.

Баян-Уул, Цагаан-Овоо, Матад сумдын Засаг дарга нарт:

1. СОНХС-гаас Баян-Уул сум 12,5 сая төгрөг, Цагаан-Овоо сум 3,2 сая төгрөг, Матад сум 22,9 сая төгрөгийг тус тус урсгал зардал зарцуулсан тул төсөвт төвлөрүүлэх.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРМАНДАХ

БИЧСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ
ШИНЖЭЭЧ

Ж.БАЯРТУУЛ
С.ЭНХБААТАР